



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн БОАЖГ-ын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/150/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас:70342580 Цахим хаяг: Erdene.B@audit.local
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Мөнхтуяа
Утас: 70342716 Цахим хаяг: MonkhtuyaP@audit.gov.mn
Аудитор:
Утас: 70342716 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.02.15 № 41
танай _____ ны № _____ Т

АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА
А.ГАНТӨМӨР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн БОАЖГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн БОАЖГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Тухайн байгууллагын хувьд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4 болон 8 дугаар зүйлийн 8.1 дэх зүйлүүдэд зааснаар тээврийн хэрэгсэл, дүрэмт хувцасны талаарх хязгаарлалтад хамрагдаагүй.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоолыг үндэслэн УАЗ пургон маркын БУА-12-24 дугаартай автомашин, 12 мотоцикл нийт 25559.8 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 24750.0 мянган төгрөгийн программ хангамжийг акталж данс бүртгэлээс хасаж тайлагнасан байна.

006020086

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 9 зорилтын хүрээнд 75 ажил төлөвлөснөөс хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр 88.8 хувиар үнэлэгдэж, 2 зорилтын 1 ажил биелэгдээгүй, 1 ажил нь дутуу хийгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>77,061,002.15</u>	<u>27,406,879.91</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	77,061,002.15	27,406,879.91
351	Түүхий эд материал	57,849,219.15	15,836,413.91
35110	Тусгай зориулалттай материал	57,849,219.15	15,836,413.91
354	Хангамжийн материал	19,211,783.00	11,570,466.00
35410	Бичиг хэргийн материал	1,968,960.00	1,530,660.00
35420	Аж ахуйн материал	4,136,955.00	5,295,056.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,545,000.00	1,660,000.00
35440	Түлш, шатах тослох материал	11,273,468.00	3,084,750.00
35470	Бусад хангамжийн материал	287,400.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>696,521,923.94</u>	<u>646,373,331.92</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	696,521,923.94	646,373,331.92
392	Биет хөрөнгө	640,885,095.94	612,937,998.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	555,469,883.97	549,311,219.32
39202	Хуримтлагдсан элэгдэл	-72,729,689.77	-80,604,641.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	158,845,523.00	123,999,999.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-77,488,381.04	-71,833,332.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	93,893,115.95	111,592,531.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-56,230,683.24	-58,382,201.93
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,007,510.00	7,362,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,630,408.31	-1,569,099.84
39214	Бусад үндсэн хөрөнгө	43,872,000.00	40,772,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,123,774.62	-7,710,974.95
393	Биет бус хөрөнгө	55,636,828.00	33,435,333.36
39301	Програм хангамж	25,245,000.00	1,684,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-25,245,000.00	-166,666.64
39303	Бусад биет бус хөрөнгө	55,636,828.00	31,918,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>773,582,926.09</u>	<u>673,780,211.83</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>773,582,926.09</u>	<u>673,780,211.83</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	773,582,926.09	673,780,211.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	438,496,996.60	438,496,996.60
51101	Өмч: - төрийн	438,496,996.60	438,496,996.60
512	Хуримтлагдсан үр дүн	65,517,993.83	-29,208,641.27
51210	Өмнөх үеийн үр дүн	65,517,993.83	70,594,072.99

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-99,802,714.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	269,567,935.66	264,491,856.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>773,582,926.09</u>	<u>673,780,211.83</u>

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	616,625,800.00	624,648,549.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,173,500.00	27,876,929.76
120	Нийтлэг татварын бус орлого	3,173,500.00	27,876,929.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,173,500.00	612,975.64
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	613,452,300.00	596,771,620.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,050,000.00	1,327,720.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,277,720.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,900,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	150,000.00	50,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	603,402,300.00	595,443,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	603,402,300.00	595,443,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	671,734,020.16	693,247,707.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	671,734,020.16	693,247,707.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	636,611,850.78	689,194,987.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	408,917,073.00	433,382,801.00
210101	Үндсэн цалин	319,839,408.00	337,051,190.00
210102	Нэмэгдэл	74,449,765.00	54,749,985.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,627,900.00	25,531,095.00
210104	Урамшуулал	00.00	16,050,531.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,010,672.62	54,376,878.56
210201	Тэтгэврийн даатгал	37,803,006.58	37,146,292.74
210202	Тэтгэмжийн даатгал	4,058,025.76	4,370,150.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,289,480.70	3,492,760.41
210204	Ажилгүйдлийн даатгал	801,024.28	850,884.74

210205	Эрүүл мэндийн даатгал	8,059,135.30	8,516,790.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,477,100.00	46,121,045.00
210301	Гэрэл, цахилгаан	8,695,600.00	6,655,295.00
210302	Түлш, халаалт	27,781,500.00	39,465,750.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,424,114.00	60,101,668.88
210401	Бичиг хэрэг	3,694,300.00	2,528,200.00
210402	Тээвэр, шатахуун	8,077,774.00	10,666,123.64
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,430,800.00	2,388,320.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	712,600.00	1,224,620.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	276,500.00	115,500.00
210408	Бараа материал акталсны зардал	6,232,140.00	43,178,905.24
2105	Нормативт зардал	00.00	350,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	350,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,582,200.00	5,976,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	589,800.00
210604	Урсгал засвар	4,582,200.00	5,386,850.00
2107	Томилолт, зочны зардал	4,839,100.00	5,088,500.00
210702	Дотоод албан томилолт	4,839,100.00	5,088,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,319,551.00	8,320,455.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,532,099.00	7,124,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	236,220.00	585,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	328,700.00	388,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210807	Газрын төлбөр	134,532.00	134,530.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,042,040.16	75,476,989.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,900,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	270,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	85,642,040.16	75,206,989.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,122,169.38	4,052,719.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,107,100.00	3,920,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,240,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,866,700.00	3,920,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,015,069.38	132,419.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-55,108,220.16	-68,599,157.54
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	31,203,556.72
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	31,203,556.72
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-31,203,556.72

5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-55,108,220.16</u>	<u>-99,802,714.26</u>
---	-------------------------	-----------------------	-----------------------

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	614,538,894.00	596,771,620.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	614,538,894.00	596,771,620.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	11,050,000.00	1,327,720.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,277,720.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,900,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	150,000.00	50,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	603,402,300.00	595,443,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	603,402,300.00	595,443,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	86,594.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	86,594.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	581,038,894.00	567,773,620.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	581,038,894.00	567,773,620.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	545,830,130.62	563,720,900.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	408,808,207.00	433,382,801.00
210101	Үндсэн цалин	319,730,542.00	337,051,190.00
210102	Нэмэгдэл	74,449,765.00	54,749,985.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,627,900.00	25,531,095.00
210104	Урамшуулал	00.00	16,050,531.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,010,672.62	54,376,878.56
210201	Тэтгэврийн даатгал	37,803,006.58	37,146,292.74
210202	Тэтгэмжийн даатгал	4,058,025.76	4,370,150.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,289,480.70	3,492,760.41

210204	Ажилгүйдлийн даатгал	801,024.28	850,884.74
210205	Эрүүл мэндийн даатгал	8,059,135.30	8,516,790.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,652,600.00	40,070,295.00
210301	Гэрэл, цахилгаан	8,695,600.00	6,655,295.00
210302	Түлш, халаалт	29,957,000.00	33,415,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,195,800.00	14,125,321.00
210401	Бичиг хэрэг	2,384,200.00	2,236,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,800,000.00	7,915,180.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,430,800.00	2,388,320.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	937,220.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	580,800.00	648,601.00
2105	Нормативт зардал	00.00	1,010,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,010,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,604,200.00	7,076,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,187,800.00
210604	Урсгал засвар	4,604,200.00	5,888,850.00
2107	Томилолт, зочны зардал	4,839,100.00	5,088,500.00
210702	Дотоод албан томилолт	4,839,100.00	5,088,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,319,551.00	8,320,455.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,532,099.00	7,124,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	236,220.00	585,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	328,700.00	388,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210807	Газрын төлбөр	134,532.00	134,530.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,400,000.00	270,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,900,000.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	270,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,208,763.38	4,052,719.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,193,694.00	3,920,300.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	86,594.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,240,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,866,700.00	3,920,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,015,069.38	132,419.44
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,015,069.38	132,419.44
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>33,500,000.00</u>	<u>28,998,000.00</u>

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	33,500,000.00	28,998,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,500,000.00	28,998,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	33,500,000.00	28,998,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33,500,000.00	28,998,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-33,500,000.00	-28,998,000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
14	Бусад эх үүсвэр	00.00	00.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	00.00	00.00
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх	00.00	00.00
145006	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих	00.00	00.00
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	00.00	00.00
145008	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	00.00	00.00
145009	Төрөл бүрийн хандив	00.00	00.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	00.00	00.00
230001	Эргэж төлөгдөх зээл	00.00	00.00
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл	00.00	00.00
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	00.00	00.00
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	00.00	00.00
240001	Гадаад зээлийн үндсэн төлбөр	00.00	00.00
241001	Засгийн газрын бондын үндсэн төлбөр	00.00	00.00
242001	Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөр	00.00	00.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	00.00	00.00
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	00.00	00.00
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	00.00	00.00
250003	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	00.00	00.00
250004	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	00.00	00.00
250005	Төлсөн ногдол ашиг	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00

9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	438,496,996.60	269,567,935.66	65,517,993.83	00.00	773,582,926.09
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	438,496,996.60	269,567,935.66	65,517,993.83	00.00	773,582,926.09
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	5,076,079.16	00.00	5,076,079.16
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	438,496,996.60	269,567,935.66	70,594,072.99	00.00	778,659,005.25
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-5,076,079.16	00.00	00.00	-5,076,079.16
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00

D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-99,802,714.26	00.00	-99,802,714.26
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	438,496,996.60	264,491,856.50	-29,208,641.27	00.00	673,780,211.83

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	611,813,900.00	595,543,384.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	611,813,900.00	595,543,384.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	607,813,900.00	591,441,180.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	445,471,400.00	433,382,801.00
210101	Үндсэн цалин	342,529,700.00	337,051,190.00
210102	Нэмэгдэл	75,423,300.00	54,749,985.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,290,600.00	25,531,095.00
210104	Урамшуулал	227,800.00	16,050,531.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,930,000.00	54,376,878.56
210201	Тэтгэврийн даатгал	38,064,500.00	37,146,292.74
210202	Тэтгэмжийн даатгал	4,478,200.00	4,370,150.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,582,600.00	3,492,760.41
210204	Ажилгүйдлийн даатгал	891,300.00	850,884.74
210205	Эрүүл мэндийн даатгал	8,913,400.00	8,516,790.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,910,600.00	40,070,295.00
210301	Гэрэл, цахилгаан	7,495,600.00	6,655,295.00
210302	Түлш, халаалт	33,415,000.00	33,415,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,876,800.00	12,847,601.00
210401	Бичиг хэрэг	2,050,000.00	2,050,000.00

210402	Тээвэр, шатахуун	7,378,000.00	7,378,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	2,388,320.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	382,680.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	648,800.00	648,601.00
2105	Нормативт зардал	1,010,000.00	1,010,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,010,000.00	1,010,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,000,000.00	35,074,650.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,000,000.00	29,185,800.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	5,888,850.00
2107	Томилолт, зочны зардал	5,088,500.00	5,088,500.00
210702	Дотоод албан томилолт	5,088,500.00	5,088,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,146,600.00	9,320,455.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,637,200.00	8,124,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	878,800.00	585,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	406,000.00	388,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000.00	88,000.00
210807	Газрын төлбөр	134,600.00	134,530.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	380000.00	270000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	380,000.00	270,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4000000.00	4019784.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,000,000.00	4,019,784.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	99,484.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	3,920,300.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	611,813,900.00	595,543,384.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	611,813,900.00	595,443,900.00
132001	Орон нутгийн төсвөөс	611,813,900.00	595,443,900.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	99,484.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	99,484.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	41.00	42.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	35.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	06.00

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,327,720.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,327,720.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,277,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,277,720.00
210401	Бичиг хэрэг	186,000.00
210402	Тээвэр, шатахуун	537,180.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	554,540.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1327720.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,327,720.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,277,720.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	50,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

2022 оныг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аян, Аялал жуулчлалыг хөгжүүлэх жил болгон зарлан ажиллажээ.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулан аяраг, сүү цагаан идээ худалдан борлуулсан иргэн ААНБ-д 1 тэрбум гаран төгрөгийн орлого олж гадаадын 8000, дотоодын 100000 гаран аялагч жуулчид манай аймгийг зорин ирсэн. "Цэвэр орчин Цэмцгэр Булган" аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулан 8598 тн хог хаягдлыг дарж булсан, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд нийт 743899 мод буыг тарьж арчлан хамгаалж байна.

Аймгийн Засаг даргатай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан нь 7 зорилго, 9 зорилтын 56 ажил арга хэмжээ, нэмэлт 19 арга хэмжээ нийт 75 ажил, арга хэмжээний хүрээнд хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр 88.8 хувиар үнэлэгдэж, 2 зорилтын 1 ажил биелэгдээгүй, 1 ажил нь дутуу хийгдсэн үзүүлэлтэй байна.

БОАЖ-ын сайдтай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилт улсын хэмжээнд 93.8%-тай үнэлэгдэж 3 дугаар байр, аймгийн ХШҮДА-ийн дүнгээр 3 дугаар байранд шалгарч “Өргөмжлөл”, мөнгөн шагналаар шагнуулжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгаль орчныг хамгаалах тухай багц хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль журмыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 тоот захирамжаар баталсан НБББББ-ыг мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод хяналттай холбоотойгоор байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг чанартай үр дүнтэй хийсэн эсэхийг шалгах аар горим хэрэгжүүлсэн.

Горим сорилоор тооллогын баримт материалтай танилцахад жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/91 тоот тушаалаар 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр томилж ажилласан байна.

Байгууллагын даргын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/34, 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/89 тоот тушаалаар тусгай зориулалтын 42672.8, бичиг хэргийн 146.1, сэлбэг хэрэгслийн 360.0 мянган төгрөгийн нийт 43178.9 мянган төгрөгийн бараа материалыг акталж данс бүртгэлээс хассан байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн БОАЖГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь НБББББ-ыг шинэчлэн батлаагүй, аймгийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 тоот захирамжаар баталсан НБББББ-ыг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн БОАЖГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг шинэчлэн батлаагүй 2020 онд баталж гаргасан НБББББ-ийг мөрдөж байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 99.8 сая төгрөгөөр буюу 13 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Бараа материал	77061.0	27406.8	49654.2
Үндсэн хөрөнгө	696521.9	646373.3	50148.6
Нийт хөрөнгө	773582.9	673780.2	99802.7
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	773582.9	673780.2	99802.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	773582.9	673780.2	99802.7

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 49654.2, үндсэн хөрөнгө 50148.6 мянган төгрөгөөр тус тус буурчээ.

НББ-ийн бодлогын өөрчлөлтөөр дахин үнэлэгдсэн барилга байгууламжийг данснаас хассан 5076079.16 төгрөгийн дахин үнэлгээний зөрүүнээс өмнөх үеийн үр дүнг залруулах бичилт хийгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 923.2 сая төгрөгөөр төлөвлөж нийт зарлагыг 923.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төсөлд тусгагдсан орон нутгийн төсвийн дүн 311.3 сая төгрөгөөр буурч, 611.8 сая төгрөгөөр батлагдсан байна.

Төсвийн буурсан шалтгаан нь 2022 оны төсөвлөсөн орон тоог бууруулан баталсантай холбон үзэж байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийг жилийн эцэст төсөвт тодотгол хийгдээгүй, орон нутгийн төсвөөс 595.4, нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Байгаль хамгаалах сангаас 1.3 сая төгрөг буюу нийт 596.7 сая

төгрөгийн санхүүжилт авсан ба урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг 16.4 сая төгрөгөөр дутуу авсан байна.

Гүйцэтгэлээр 596.6 сая төгрөгийн зарцуулж 0.1 сая төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлж тайлагнажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 596.6 сая төгрөг буюу 97.5 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	607813.9	592851.3	14962.6	97.5
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж	4000.0	3920.0	0.8	98

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Булган аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр-2022, аймгийн аялал жуулчлалын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Айраг наадам”-ын зардалд 1.2 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан авч бичиг хэргийн зардалд 0.2, тээвэр шатахууны зардалд 0.5, хог хаягдал зайлуулах зардалд 0.5 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хөтөлбөр хэрэгжээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн БОАЖГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн БОАЖГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүжилтийн дүнгийн 611813.9 мянган төгрөгөөс 75 хувиар буюу 6882.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь сургалт семинарыг цахимаар зохион байгуулсан, сул орон тоог хавсран гүйцэтгүүлэх журмаар төрийн үйлчилгээг тасралтгүй хэрэгжүүлж цалингийн зардлыг 12.1, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.8, эд хогшил урсгал засварын зардлыг 1.0, ажил олгогчоос олгох шимтгэлийн зардлыг 1.5, тэтгэмжийн зардлыг 0.08 сая төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

Мөн төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор нийт 32 горим сорил хэрэгжүүлж баримтжуулан ажиллалаа.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2022 онд 151 мэдээ мэдээлэхээс хуулийн хугацаанд бүрэн мэдээлж ажиллажээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж тогтоогоогүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Аймгийн БОАЖГ нь 2022 оны 05 дүгээр сарын 30-ны өдрийн 31 тоот албан бичгээр акт, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт	Биелэлт
----------	------------------------	---------

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	67.0	1	67.0	100
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	2	322.9	2	322.9	100
Нийт дүн	3	389.0	3	389.0	100

Хэрэгжээгүй зөвлөмж байхгүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын ажилчдад олгох хоолны мөнгөний тушаал шийдвэрийг байгууллагын дотоод журмын заалтыг оруулан гаргаж байхыг аудитын явцад зөвлөж ажиллалаа.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулсан алдаа илрээгүй болно.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй болно.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж хүргүүлээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

